



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар A/100

Ховд

Г Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай Г

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, 16.4.2 дахь заалтууд, Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2.1, 2.2 дахь хэсэтг заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1 Байгууллагын зүгээс ажилтан албан хаагчдын гэр бүлд хөгжих боломжийг бүрдүүлэх, тогтвортой байдлыг дэмжих, тэдний хэрэгцээ шаардлагад үндэслэн бодитой дэмжлэгийг бий болгон ажиллах “Эцэг эхийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Зөвлөлийн хүрээнд байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулж зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, тайланг жил бүр Хүүхдийн төлөө зөвлөлд танилцуулж ажиллахыг Хууль эрх зүйн хэлтсийн дарга, эцэг эхийн зөвлөлийн дарга /Н.Ганзориг/-д даалгасугай.


3. Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, улирал тутамд хамт олны хурлаар зөвлөлийн үйл ажиллагааг тайлагнаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, эцэг эхийн зөвлөлийн нарийн бичгийн дарга /Д.Бямбасүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭНХБОЛД



Аймгийн Засаг даргын Тамгын газрын
2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн
A/100 дугаар тушаалын хавсралт



ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Зөвлөлийн дарга: Н.Ганзориг –Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,
эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:
Б.Батнасан –Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, төрийн сангийн хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Х.Баасанхүү –Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Гантэмэр –Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Одгэрэл -Цэргийн штабын мэргэжилтэн

Б.Нямдэлгэр -Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Санхүү, аж ахуйн тасгийн дарга бөгөөд
ерөнхий нягтлан бодогч

Б.Түмэнжаргал -“Угтах үйлчилгээ-1111 төв”-ийн оператор

Г.Оюунцэцэг -Үйлчилгээний албаны ажилтан

Зөвлөлийн нарийн бичгийн дарга:

Д.Бямбасүрэн –Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн